


**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ  
ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ,  
ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН  
ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ  
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаягаар, эсхүл дараах QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.



**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ, ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**



**Нэг. Гадаад худалдааны үзүүлэлт**

**Гадаад худалдааны нийт бараа эргэлт:** 2024 оны эхний 12 сард Монгол улс дэлхийн 160 оронтой худалдаа хийж гадаад худалдааны нийт бараа эргэлт **27,395.9** сая ам.доллар болж 2023 оны мөн үеэс 2,958.9 сая ам.доллар буюу 12.1 хувиар өсчээ. Экспортын дүн импортын дүнгээс **4,170.9** сая ам.доллараар давж, гадаад худалдааны баланс эерэг гарлаа.

**Хүснэгт 1.** Гадаад худалдааны үзүүлэлт

Үзүүлэлт	эхний 12 сар				Өөрчлөлт	
	2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	16,095.8	21,243.0	24,437.1	27,395.9	2,958.7	12.1
-Экспорт	9,247.1	12,538.6	15,186.9	15,783.4	596.5	3.9
-Импорт	6,848.6	8,704.4	9,250.2	11,612.5	2,362.2	25.5
Тэнцэл	2,398.5	3,834.2	5,936.6	4,170.9	-1,765.7	-29.7

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**Гадаад худалдааны тэнцэл:** 2024 оны эхний 12 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны тэнцэл **4,170.9** сая ам.долларын ашигтай гарсан байна. Өмнөх оны мөн үеэс 1,765.7 сая ам.доллараар буурахад импортын өсөлт 2,362.2 сая ам.доллараар нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

**Импорт:** 2024 оны эхний 12 сарын гүйцэтгэлээр импорт **11,612.5** сая ам.долларт хүрч, 2023 оны мөн үетэй харьцуулахад 2,362.2 сая ам.доллар буюу 25.5 хувиар өссөн байна.

**Экспорт:** 2024 оны эхний 12 сарын гүйцэтгэлээр экспорт **15,783.4** сая ам.доллар болж, 2023 оны мөн үетэй харьцуулахад 596.5 сая ам.доллар буюу 3.9 хувиар өссөн байна.

**Хоёр. Гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн**

Нийт экспортын **87.2** хувийг эрдсийн бүтээгдэхүүний экспорт, **12.8** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт эзэлж байна. Эрдсийн бүтээгдэхүүний экспорт **13,769.8** сая ам.доллар болж, өмнөх оноос 623.4

сая ам.доллар буюу 4.7 хувиар өссөн бол эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт **2,013.6** сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 26.9 сая ам.доллар буюу 1.3 хувиар буурсан байна.

**Хүснэгт 2.** Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт

Үзүүлэлт	эхний 12 сар				Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2021	2022	2023	2024	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	7,516.0	10,543.3	13,146.5	13,769.8	623.4	4.7	87.2
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	1,731.2	1,995.3	2,040.4	2,013.6	-26.9	-1.3	12.8
Нийт экспорт	9,247.1	12,538.6	15,186.9	15,783.4	596.5	3.9	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**ЭКСПОРТЫН ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ТОО ХЭМЖЭЭ БОЛОН ҮНИЙН ДҮН**

Нийт экспортын 54.1 хувийг нүүрс, 21.0 хувийг зэсийн баяжмал, 5.7 хувийг алт, 3.8 хувийг төмрийн хүдэр, түүхий нефть болон

газрын тос болон жоншны баяжмал 2.0 хувийг тус тус эзэлсэн байна.

**Хүснэгт 3.** Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	эхний 12 сар		Өмнөх оны мөн үеэс	
		2023	2024	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	мян.тн	1,525.0	1,695.4	170.4	11.2
Нүүрс	сая.тн	66.7	79.5	12.8	19.2
Төмрийн хүдэр	сая.тн	5.7	7.5	1.8	31.5
Цайрын баяжмал	мян.тн	150.5	126.2	-24.3	-16.1
Алт	тн	11.7	11.6	-0.1	-0.8
Түүхий нефть болон газрын тос	сая.баррель	4.7	4.1	-0.7	-13.9
Катодын зэс	мян.тн	12.5	13.2	0.6	5.0
Жоншны баяжмал	мян.тн	1,087.8	1,369.1	281.3	25.9
Адууны мах	мян.тн	32.9	23.9	-9.1	-27.6
Өлөн гэдэс	мян.тн	0.7	0.8	0.1	8.3

Үхэр, адууны боловсруулсан шир	сая.дм2	10.0	50.7	40.7	406.9
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян.ш	516.2	282.8	-233.4	-45.2
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая.дм2	39.9	0.4	-39.5	-99.0
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая.дм2	59.3	45.7	-13.6	-23.0
Ямааны самнасан ноолуур	мян.тн	1.0	0.7	-0.3	-29.3
Ямааны угаасан ноолуур	мян.тн	5.4	4.8	-0.7	-12.4
Самнаагүй хонины ноос	мян.тн	13.3	8.2	-5.1	-38.2

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**Хүснэгт 4. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого**

/сая ам.доллар/

Барааны төрөл	эхний 12 сар		Өмнөх оны мөн үеэс		Экспортод эзлэх хувь
	2023	2024	Дүн	Хувь	
Зэсийн баяжмал	2,625.7	3,319.1	693.4	26.4	21.0
Нүүрс	8,764.3	8,534.9	-229.4	-2.6	54.1
Төмрийн хүдэр	444.7	597.6	152.8	34.4	3.8
Цайрын баяжмал	220.0	183.3	-36.7	-16.7	1.2
Алт	738.0	899.4	161.4	21.9	5.7
Түүхий нефть болон газрын тос	364.7	322.1	-42.6	-11.7	2.0
Тунгаасан зэс ба хайлш	102.5	116.7	14.2	13.8	0.7
Жоншны баяжмал	272.4	318.5	46.2	16.9	2.0
Адууны мах	125.5	84.2	-41.3	-32.9	0.5
Өлөн гэдэс	11.6	13.3	1.6	13.9	0.1
Үхэр, адууны боловсруулсан шир	0.6	1.2	0.6	90.7	0.0
Үхэр, адууны боловсруулаагүй шир	1.1	0.7	-0.4	-38.4	0.0
Хонь, хурганы боловсруулсан арьс	0.6	0.0	-0.6	-99.3	0.0
Ямаа, ишигний боловсруулсан арьс	1.5	1.1	-0.3	-22.1	0.0
Ямааны самнасан ноолуур	95.9	69.8	-26.0	-27.2	0.4
Ямааны угаасан ноолуур	264.0	256.7	-7.2	-2.7	1.6
Хонины самнаагүй ноос	14.0	8.9	-5.0	-35.9	0.1
<b>Нийт экспортод эзлэх хувь</b>	<b>92.5</b>	<b>93.3</b>			

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оны мөн үеэс 623.4 сая ам.доллар буюу 4.7 хувиар өсөхөд голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

**Нүүрс:** 2024 оны эхний 12 сарын гүйцэтгэлээр 8,534.9 сая ам.долларын 79.5 сая.тн нүүрс экспортолсон байна. Нүүрсний экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 229.4 сая ам.доллар буюу 2.6 хувиар буурч, биет хэмжээ 12.8 сая.тн буюу 19.2 хувиар өссөн байна. Нүүрсийг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна. Нэг тонн чулуун нүүрсний зах зээлийн үнэ 2024 оны 12 дугаар сарын байдлаар 107.3 ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс **18.3 хувиар буурсан** байна.

**Зэсийн баяжмал:** 2024 оны эхний 12 сарын гүйцэтгэлээр 3,319.1 сая ам.долларын 1,695.4 мян.тн зэсийн баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс экспортын орлого 693.4 сая ам.доллар буюу 26.4 хувиар, биет хэмжээ 170.4 мян.тн буюу 11.2 хувиар тус тус өссөн байна. Зэсийн баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна. Нэг тонн зэсийн баяжмалын зах зээлийн үнэ 1,957.7 ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **13.7 хувиар өссөн** үзүүлэлттэй байна.

**Алт:** 2024 оны эхний 12 сарын гүйцэтгэлээр 899.4 сая ам.долларын 11.6 тонн алт экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс экспортын орлого 161.4 сая ам.доллар буюу 21.9 хувиар өсч, биет хэмжээ 0.1 тонн буюу 0.8 хувиар буурсан байна. Алтны 82.4 хувийг Швейцар, 17.3 хувийг АНУ руу тус тус экспортолсон байна. Нэг килограм алтны зах зээлийн үнэ 77,233.0 ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс **22.8 хувиар өссөн** байна.

**Төмрийн хүдэр, баяжмал:** 2024 оны эхний 12 сарын гүйцэтгэлээр 597.6 сая ам.долларын 7.5 сая.тн төмрийн хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс экспортын орлого 152.8 сая ам.доллар буюу 34.4 хувиар, биет хэмжээ 1.8 сая.тн буюу 31.5 хувиар тус тус өссөн байна. Төмрийн хүдэр, баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна. Нэг тонн төмрийн хүдрийн зах зээлийн үнэ 79.6 ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс **2.2 хувиар өссөн** байна.

**Нефть:** 2024 оны эхний 12 сарын гүйцэтгэлээр 322.1 сая ам.долларын 4.1 сая.бар газрын тос экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 0.7 сая.бар буюу 13.9 хувиар, экспортын орлого 42.6 сая ам.доллар буюу 11.7 хувиар тус тус буурсан байна. Газрын тосыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

**Хүснэгт 5. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ**

/сая ам.доллар/

Барааны нэр	Хэмжих нэгж	эхний 12 сар		Өөрчлөлт	
		2023	2024	Дүн	Хувь
Чулуун нүүрс	тн/ам.дол	131.4	107.3	-24.1	-18.3
Зэсийн баяжмал	тн/ам.дол	1,721.7	1,957.7	236.0	13.7
Төмрийн хүдэр, баяжмал	тн/ам.дол	77.8	79.6	1.7	2.2
Цайрын баяжмал	тн/ам.дол	1,462.2	1,452.3	-9.8	-0.7
Хайлууур жоншны хүдэр, баяжмал	тн/ам.дол	250.4	232.6	-17.7	-7.1
Молибдены баяжмал	тн/ам.дол	18,939.0	15,993.6	-2,945.4	-15.6
Алт	кг/ам.дол	62,897.7	77,233.0	14,335.3	22.8

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**Гурав. Гол нэр төрлийн импортын бүтээгдэхүүн**

Манай улс дэлхийн 158 орноос гарал үүсэлтэй бараа импортлосноос БНХАУ-д 40.0 хувь; ОХУ-д 24.3 хувь; Япон-д 10.1 хувь; АНУ-д 4.6 хувь; БНСУ-д 4.2 хувь; ХБНГУ-д 2.2 хувь тус тус ногдож байгаа нь нийт импортын дүнгийн 85.4 хувийг эзэлж байна.

Нийт импортын **21.1** хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, **78.9** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт **2,444.6** сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 304.2 сая ам.доллараар буюу 14.2 хувиар өссөн байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт **9,167.9** сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 2,058.0 сая ам.доллар буюу 28.9 хувиар өссөн байна.



**Хүснэгт 6. Эрдсийн болон эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт**

/сая ам.доллар/

Үзүүлэлт	эхний 12 сар				Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2021	2022	2023	2024	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	1,338.6	1,960.3	2,140.3	2,444.6	304.2	14.2	21.1
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	5,510.1	6,744.1	7,109.9	9,167.9	2,058.0	28.9	78.9
<b>Нийт импорт</b>	<b>6,848.6</b>	<b>8,704.4</b>	<b>9,250.2</b>	<b>11,612.5</b>	<b>2,362.2</b>	<b>25.5</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын барааны бүтцийн хувьд эрдэс бүтээгдэхүүн 22.9 хувь, машин механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг 15.9 хувь, авто болон агаарын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 13.1 хувь, мал амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн,

хүнсний зүйл 9.9 хувь, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн 9.4 хувь, химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн 7.4 хувийг тус тус эзэлж байна.

**Хүснэгт 7. Импортын гүйцэтгэл, барааны бүлгээр**

/сая ам.доллар/

№	Барааны нэр	эхний 12 сар		Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
		2023	2024	Дүн	Хувь	
1	Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	25.6	41.1	15.5	60.7	2.4
2	Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	83.6	38.4	-45.1	-54.0	2.3
3	Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	14.8	13.6	-1.3	-8.5	0.8
4	Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	123.7	167.3	43.6	35.2	9.9
5	<b>Эрдэс бүтээгдэхүүн</b>	<b>276.8</b>	<b>386.5</b>	<b>109.7</b>	<b>39.6</b>	<b>22.9</b>
6	Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн	97.4	124.7	27.3	28.1	7.4
7	Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс; хаймар болон түүгээр хийсэн зүйлс	57.8	68.8	11.0	19.1	4.1
8	Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	1.5	1.6	0.2	13.0	0.1
9	Мод, модон эдлэл	8.8	21.1	12.3	140.3	1.3
10	Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс	14.7	20.8	6.0	41.0	1.2
11	Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл	22.3	33.4	11.1	49.6	2.0
12	Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	4.7	6.7	2.0	41.8	0.4
13	Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	31.7	42.5	10.9	34.3	2.5
14	Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	1.9	2.7	0.8	44.8	0.2
15	Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	99.8	159.2	59.4	59.5	9.4
16	<b>Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг</b>	<b>263.0</b>	<b>269.1</b>	<b>6.1</b>	<b>2.3</b>	<b>15.9</b>
17	<b>Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги</b>	<b>346.7</b>	<b>222.0</b>	<b>-124.7</b>	<b>-36.0</b>	<b>13.1</b>
18	Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг эдгээрийн эд анги	28.6	39.0	10.4	0.0	0.0
19	Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа	1.5	0.4	-1.1	0.0	0.0
20	Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	19.0	31.9	12.9	0.1	0.0
21	Бусад	0.0	0.0	0.0	0.0	0.0
	<b>ДҮН</b>	<b>1,523.7</b>	<b>1,690.7</b>	<b>167.0</b>	<b>11.0</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**Дөрөв. Улсын төсвийн гаалийн орлого бүрдэлт**

Гаалийн байгууллага нь 2024 оны эхний 12 сард нийт 6,792.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс **6,743.7** тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд гүйцэтгэл **99.3** хувьтай байна.

Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулбал нийт орлого өнгөрсөн оны мөн үеэс 1,415.0 тэрбум төгрөгөөр буюу 26.6 хувиар өссөн байна.

**Хүснэгт 8. Татварын орлогын гүйцэтгэл**

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2023.12	2024.12		Өмнөх оны мөн үетэй харьцуулахад		Орлогын биелэлтийн хувь
	Гүйц.	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь	
<b>Нийт орлого</b>	<b>5,328.7</b>	<b>6,792.9</b>	<b>6,743.7</b>	<b>1,415.0</b>	<b>26.6</b>	<b>99.3</b>
Гаалийн албан татвар	1,465.3	1,934.7	1,794.6	329.3	22.5	92.8
Нэмэгдсэн өртгийн албан татвар	3,158.4	4,060.2	3,952.2	793.8	25.1	97.3
Архи, дарсны онцгой албан татвар	40.5	50.0	64.4	23.9	59.0	128.8
Тамхины онцгой албан татвар	146.9	150.0	147.5	0.6	0.4	98.3
Шар айрагны онцгой албан татвар	8.3	10.0	12.5	4.2	50.6	125.0
Суудлын автомашины онцгой албан татвар	321.0	400.0	582.1	261.1	81.3	145.5
Автобензин, дизель түлшний онцгой албан татвар	13.2	10.0	3.7	-9.5	-72.0	37.0
Автобензин, дизель түлшний албан татвар	21.6	28.0	26.4	4.8	22.2	94.3
Экспортын татвар	0.04	0.04	0.02	0.0	-45.0	55.0
<b>Татварын дүн</b>	<b>5,175.2</b>	<b>6,642.9</b>	<b>6,583.4</b>	<b>1,408.2</b>	<b>27.2</b>	<b>99.1</b>
Хураамж	123.5	135.0	146.4	22.9	18.5	108.4
Өөрийн орлого	30.0	15.0	13.9	-16.1	-53.7	92.7

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулбал нийт орлого өнгөрсөн оны мөн үеэс 1,415.0 тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд:

- Нэмэгдсэн өртгийн албан татвар 793.7 тэрбум төгрөг;
- Гаалийн албан татвар 329.3 тэрбум төгрөг;
- Суудлын автомашины онцгой албан татвар 261.1 тэрбум төгрөг;
- Архи, дарсны онцгой албан татвар 23.9 тэрбум төгрөг;
- Хураамжийн орлого 22.9 тэрбум төгрөг;
- Автобензин дизелийн түлшний албан татвар 4.8 тэрбум төгрөг;
- Шар айрагны онцгой албан татвар 4.2 тэрбум төгрөг;
- Тамхины онцгой албан татвар 0.5 тэрбум төгрөгөөр тус тус өссөн.

Харин автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар 9.4 тэрбум төгрөг, өөрийн орлого 15.6 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

### Тав. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

2024 онд нийт импортод татвартай импорт **93.9** хувь, татвараас чөлөөлөгдсөн импорт үнийн дүнгээрээ **6.1** хувийг тус тус эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татвартай импорт 7,076.6 тэрбум төгрөгөөр буюу 23.7 хувиар өссөн бол, татвараас чөлөөлөгдсөн импорт **350.5** тэрбум төгрөгөөр буюу **17.3** хувиар өссөн үзүүлэлттэй байна.

#### Хүснэгт 9. Импортын бүтэц

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	эхний 12 сар		Өмнөх оны мөн үетэй харьцуулахад		Импортод эзлэх хувь
	2023	2024	Зөрүү	Хувь	
Татвартай импорт	29,797.8	36,874.4	7,076.6	23.7	93.9
Татвараас чөлөөлөгдсөн импорт	2,027.3	2,377.8	350.5	17.3	6.1
<b>Нийт</b>	<b>31,825.1</b>	<b>39,252.2</b>	<b>7,427.1</b>	<b>23.3</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Татвараас чөлөөлөгдсөн импорт нь 2024 онд 2,377.8 тэрбум төгрөгт хүрч, түүнд ногдуулсан 347.8 тэрбум төгрөгийн татварыг хуулийн дагуу чөлөөлөгдсөн байна.

#### Хүснэгт 10. Импортын гүйцэтгэл, барааны бүлгээр

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2023 он		2024 он		Өөрчлөлт	
	Импортын дүн	Чөлөөлсөн татвар	Импортын дүн	Чөлөөлсөн татвар	Импортын дүн	Чөлөөлсөн татвар
ХАА-н зориулалттай тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис	194.3	20.4	222.5	23.4	28.2	3.0
Засгийн газрын болон Олон улсын байгууллагын тусламж	164.8	25.6	275.3	42.8	110.5	17.3
Гадаадын хөрөнгө оруулалт: УБТЗ болон газрын тосны компаниудын тоног төхөөрөмж	426.5	66.7	554.0	85.9	127.5	19.2
Сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг	64.1	7.8	148.0	21.4	83.9	13.6
Иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг онгоц, түүний сэлбэг	374.7	58.4	210.7	33.4	-164.0	-25.0
Засгийн газрын болон олон улсын байгууллагын зээл	600.1	90.6	413.7	63.6	-186.4	-27.1
Хийн түлш тэдгээрийн тоног төхөөрөмж	99.8	15.5	100.8	15.6	1.0	0.1
Бусад	277.9	40.8	452.9	61.7	175.1	20.9

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

### Зургаа. Улсын төсвийн гаалийн орлогод нөлөөлсөн хүчин зүйлс

Гаалийн байгууллага нь УИХ, Засгийн газраас баталсан хууль тогтоомжийг хэрэгжүүлж, татварын хойшуулалт, чөлөөлөлт, хөнгөлөлтөөр 205.8 тэрбум төгрөгийн татварыг улсын төсөвт төвлөрүүлэх боломжийг алдсан байна. Үүнд:

Тариф хувь хэмжээний бууралт **5.9** + Татварын чөлөөлөлт **5.5** + ханшний нөлөөллөөр **111.2** + Татварын хойшуулалт **83.2 = 205.8** тэрбум төгрөг

### Ханшны нөлөөллөөр нийт 111.6 тэрбум төгрөг

Ханшийн 2.3 хувийн бууралтаас гаалийн байгууллага нь нийт 111.2 тэрбум төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлэх боломж алдагдсан.

#### Хүснэгт 11. Ханшийн нөлөөлөл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	эхний 12 сар		өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад	
	2023	2024	Өөрчлөлт	Дүн
Татвартай импорт /сая ам. доллар/	8,628.6	10,931.8	2,303.2	26.7
Татвартай импорт/тэрбум төгрөг/	29,797.8	36,874.4	7,076.6	23.8
Гаалийн албан татвар болон Нэмэгдсэн өртгийн албан татвар /тэрбум төгрөг/	4,623.7	5,746.8	1,123.0	24.3
Дундаж ханш /төгрөг/	3,453.4	3,373.2	-80.2	-2.3
2023 оны эхний 11 сарын дундаж ханшаар тооцсон импорт / тэрбум төгрөг/	29,797.8	37,751.5	7,953.7	26.7
2023 оны эхний 11 сарын дундаж ханшаар тооцсон татвар /тэрбум төг/	4,623.7	5,857.9	1,234.2	26.7
Ханшны зөрүүнээс буурсан татвар /тэрбум төг/		111.2		

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

#### Тарифын хөнгөлөлт, татварын чөлөөлөлт

а) Загийн газрын 2024 оны 188-р тогтоолоор батлагдсан Цементийн албан татварын хувь хэмжээг 20 хувь байсныг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2024 оны 10 дугаар сарын 01-ныг хүртэл хугацаанд 5% болгон бууруулсан тогтоолыг тарифын санд оруулж хэрэгжилтэд хяналт тавьсан. Нийт 10.8 сая ам.долларын дүн бүхий 174.4 мянган тонн, **5.5** тэрбум төгрөгийн татварыг хөнгөлсөн байна.

б) 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Засгийн газрын 180 дугаар тогтоолыг тус тус үндэслэн импортын малын тэжээл болон гурил бүхий бараанд ногдуулвал зохих **5.9** тэрбум төгрөгийн гаалийн албан татварыг чөлөөлжээ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН  
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС